

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэ сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2024/46/НА-СТА-ТШЗ

|                                                                                      |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                         |
|--------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a><br>Алтай хот<br>2024 он | Дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа<br>Утас: 70483413 Цахим хаяг:<br>Хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер: Д.Эрдэнэчимэг<br>Утас: 70484055 Цахим хаяг: <a href="mailto:erdenechimegd@audit.gov.mn">erdenechimegd@audit.gov.mn</a><br>"Цэгц төв богд аудит" ХХК-ийн<br>Ахлах аудитор Р.Цанжидмаа<br>Утас: 99029885 Цахим хаяг: <a href="mailto:tsania.0215@gmail.com">tsania.0215@gmail.com</a> |
|--------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,  
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099  
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,  
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn  
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.21 № 43

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрдэнэ сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрдэнэ сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Тус Эрүүл мэндийн төв тайлант онд Эрүүл мэндийн даатгалын хэлтэстэй байгуулсан гэрээний дагуу 2316 хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлсэн байна.

### Аудитын гол асуудал

Эрүүл мэндийн даатгалын сангаас эрүүл мэндийн тусламж үйлчилгээний болон нэг иргэнд ногдох санхүүжилт 592,368.9 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс байр ашиглалттай холбоотой зардлын санхүүжилт 33,050.0 мянган төгрөг, хандив тусламжаар 58,996.3 мянган төгрөгийн эм бэлдмэл, эмнэлгийн тоног төхөөрөмж үнэ төлбөргүй орлого авчээ.

### Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 4 хөтөлбөр, 48 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 42 арга хэмжээг 100.0 хувь, 1 арга хэмжээг 90.0 хувь, 5 арга хэмжээг 70.0 хувь биелэлтийг хүргүүлжээ. Сумын Засаг даргын гэрээний биелэлтийг 95 хувь үнэлжээ. Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ худалдан авах гэрээгээр 77.28 хувиар үнэлэгдсэн байна.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА



Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/мянган. төгрөг/

|                                                | Үзүүлэлт                                          | 2022.12.31        | 2023.12.31        |
|------------------------------------------------|---------------------------------------------------|-------------------|-------------------|
| <b>Санхүүгийн байдлын тайлан</b>               |                                                   |                   |                   |
|                                                | Эргэлтийн хөрөнгийн дүн                           | 217,554.8         | 216,621.3         |
|                                                | Эргэлтийн бус хөрөнгийн дүн                       | 592,677.3         | 569,213.4         |
|                                                | <b>Нийт хөрөнгийн дүн</b>                         | <b>810,232.1</b>  | <b>785,834.7</b>  |
|                                                | Нийт өр төлбөрийн дүн                             |                   |                   |
|                                                | Цэвэр хөрөнгө/өмчийн дүн                          | 810,232.1         | 785,834.7         |
|                                                | <b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>        |                   |                   |
| <b>Санхүүгийн үр дүнгийн тайлан</b>            |                                                   |                   |                   |
|                                                | Үйл ажиллагааны орлогын дүн                       | 1,310,661.1       | 684,415.2         |
|                                                | Үйл ажиллагааны зардлын дүн                       | 597,216.8         | 698,792.6         |
|                                                | <b>Үйл ажиллагааны үр дүн</b>                     | <b>713,444.3</b>  | <b>(14,377.3)</b> |
|                                                | Үйл ажиллагааны бус үр дүн                        | (0.64)            | (10,020.00)       |
|                                                | <b>Үйл ажиллагааны нийт үр дүн</b>                |                   | <b>(24,397.3)</b> |
| <b>Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан</b> |                                                   |                   |                   |
|                                                | Дахин илэрхийлсэн үлдэгдэл                        | 96,787.8          | 810,232.1         |
|                                                | Тайлант оны үр дүн                                | 713,444.3         | (24,397.3)        |
|                                                | <b>Эцсийн үлдэгдэл</b>                            | <b>810,232.1</b>  | <b>785,834.8</b>  |
| <b>Мөнгөн гүйлгээний тайлан</b>                |                                                   |                   |                   |
|                                                | Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн                | 714,373.5         | 617,298.1         |
|                                                | Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн               | 529,609.1         | 625,284.4         |
|                                                | <b>Үйл ажиллагааны ЦМГ</b>                        | <b>184,764.4</b>  | <b>(7,986.3)</b>  |
|                                                | <b>Хөрөнгө оруулалтын ЦМГ</b>                     | <b>(58,278.0)</b> | <b>(27,596.0)</b> |
|                                                | <b>Санхүүгийн ажиллагааны ЦМГ</b>                 |                   |                   |
|                                                | <b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>                  | <b>126,486.4</b>  | <b>(35.58263)</b> |
|                                                | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл  |                   | 126,486.3         |
|                                                | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 126,486.3         | 90,904.1          |
| <b>Төсвийн гүйцэтгэлийн тайлан УТ</b>          |                                                   |                   |                   |
|                                                | <b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>          |                   | <b>619,830.4</b>  |
|                                                | Урсгал зардал                                     |                   | 619,830.4         |
|                                                | Хөрөнгийн зардал                                  |                   | -                 |
|                                                | <b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>             |                   | <b>584,248.1</b>  |
|                                                | Эрүүл мэндийн даатгалын сангаас                   |                   | 583,132.5         |
|                                                | Туслах үйл ажиллагааны орлогоос                   |                   | 1,115.6           |
|                                                | Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл                         | 126,486.3         | 90,904.1          |
| <b>Төсвийн гүйцэтгэлийн тайлан ОН</b>          |                                                   |                   |                   |
|                                                | <b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>          |                   | <b>33,050.0</b>   |
|                                                | Урсгал зардал                                     |                   | 33,050.0          |
|                                                | Хөрөнгийн зардал                                  |                   | -                 |
|                                                | <b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>             |                   | <b>22,935.9</b>   |
|                                                | Орон нутгийн төсвөөс санхүүжих                    |                   | 22,935.9          |

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар залруулагдаагүй 6.1 сая төгрөгийн алдаа, зөрчлөөс 0.4 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт, 5.7 сая төгрөгийн 2 зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх талаар албан шаардлага өгсөн.

## 5.1 Төлбөрийн акт

1. Сахилгын шийтгэлтэй ажилтанд 0.4 сая төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.8-т "Хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл ажилтныг хөдөлмөрийн сахилгын шийтгэлгүйд тооцно", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2 дугаар зүйлийн 2.7-т "Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй" гэж заасныг зөрчиж байна

Шийдвэрлсэн нь: Төсвийг хохиролгүй болгох төлбөрийн акт тогтоосон.

## 5.2 Албан шаардлага

1. Тендерт шалгараагүй 4 аж ахуйн нэгж байгууллагаас 5.7 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг худалдан авсан нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно." гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тендерт шалгарсан этгээдээс худалдан авалт хийж байх албан шаардлага хүргүүлсэн.

2. Эмийн үлдэгдэлд хугацаа дууссан 54 нэр төрлийн 6.9 төгрөгийн эм байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх"; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6-т "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал бэлтгэх, нөөцлөх"; гэж гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дотоодын хяналтыг сайжруулан хугацаа дууссан эмийг холбогдох журмын дагуу шийдвэрлэх шардлага хүргүүлсэн

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:**

[illegible]



|  |   |     |   |     |   |     |  |  |  |  |  |  |
|--|---|-----|---|-----|---|-----|--|--|--|--|--|--|
|  | 3 | 6.2 | 1 | 0.4 | 2 | 5.7 |  |  |  |  |  |  |
|--|---|-----|---|-----|---|-----|--|--|--|--|--|--|

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо |                             |                    |                 | Санал дүгнэлтийн хэлбэр |                |       |                            |
|---|-----------------------------|--------------------------|-----------------------------|--------------------|-----------------|-------------------------|----------------|-------|----------------------------|
|   |                             | Аудитад хамрагдах        | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр |                    |                 | Өөрчлөлтгүй             | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
|   |                             |                          | Санал дүгнэлт гаргасан      | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй |                         |                |       |                            |
| A | 1                           | 2                        | 3                           | 4                  | 5               | 7                       | 8              | 9     | 10                         |
| 1 | ТШЗ                         | 1                        | 1                           | -                  | -               | 1                       | -              | -     | -                          |
|   | НИЙТ                        | 1                        | 1                           | -                  | -               | 1                       | -              | -     | -                          |